



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/180

Номрон

Эрчим хүчний төлөвлөлтийн
нийтийн сонгол хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Нийтийн сонсголын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.2.5, Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний төлөвлөлтийн нийтийн сонсголыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр, сэргээгдэх эрчим хүчний үзэсгэлэн, өдөрлөгийг 05 дугаар сарын 2-3-ны хооронд зохион байгуулсугай.

2. Эрчим хүчний төлөвлөлтийн нийтийн сонсголыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Энхбаяр

Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

О.Батболд

Монголын тогтвортой хөгжил, нийгмийн хариуцлагын зөвлөлийн Удирдах зөвлөлийн дарга

М.Насанбат

Баянхонгор сумын Засаг дарга

А.Цэцэнбилэг

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Бат-Өлзий

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

С.Баярмагнай

Иргэний төлөөлөл

А.Түвшинбилэг

Баянхонгор аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн

Д.Энхтүвшин

Баянхонгор аймаг дахь Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга

Нарийн бичгийн дарга:

Ж.Уламбаяр

“Баянхонгор Эрчим хүч” ЦТХХК-ийн Гүйцэтгэх захирал

626010483

2.Эрчим хүчний төлөвлөлтийн нийтийн сонголыг Монгол Улсын Их Хурлын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт "Нийтийн сонгол зохион байгуулах журам"-ын хүрээнд аймгийн хэмжээнд холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, аж ахуйн нэгж, иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх, нийтийн сонсголоос гарсан санал, зөвлөмж, бусад материалыг архив, бичиг хэргийн стандарт шаардлагад нийцүүлэн боловсруулж байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

